



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/24

Чойбалсан

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.4, 5.5 дугаар зүйлийн 10, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.5, 19.18 дахь заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дугаар тушаал, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2023 оны гуравдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дорнын Очирт мандал” ХХК-ийн “Оюу фарм” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгаж, хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эм зүйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг “Оюу фарм” эмийн сангийн эрхлэгчид үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажлын албанд даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
07 сарын 07 ны/ний өдрийн
Аж дугаар/дүгээр тушаалын хавсралт

9031774 40719110008

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

| № | Хуулийн этгээдийн нэр | Оноосон нэр | Байршил | Тусгай зөвшөөрлийн дугаар | Үйл ажиллагааны чиглэл | Сунгасан жил | Хүчинтэй хугацаа | |
|---|--------------------------|-------------------------|--|---------------------------------|------------------------------|-----------------|------------------|------------|
| | | | | | | | Эхлэх | Дуусах |
| 1 | "Дорнын Очирт" мандал | "Оюу фарм" эмийн сан | Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг 20-р байр 01 ТООТ | ЭСХ-16/09/882 | Эмийн сан II зэрэглэл | 5 жил | 2023.06.30 | 2028.06.30 |

00000